



Нэгдсэн
Үндэстний
Байгууллага



Ирээдүйгээ
амтдаа
цогцлох нь



Нийт хугацаа: 45-50 минут орчим
Насны бүлэг: 6-10 насныхан

НҮБ-ын 80 ЖИЛИЙН ОЙГ ХАМТДАА ТЭМДЭГЛЭЕ СЭДЭВТ БАГА АНГИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



Сургалтаас хүлээх үр дүн

- Дасгал, агуулгын хүрээнд НҮБ гэж юу вэ, яагаад байгуулагдсан тухай ойлголттой болох
- НҮБ хүмүүсийн амьдралд хэрхэн тусалдаг талаар мэдлэгтэй болох
- Ирээдүйд НҮБ хэрхэн ажиллавал зохистой тухайд өөрийн төсөөлөл, санаа бодлоо илэрхийлэх

Ашиглах материал

- Сурагчдад зориулж бэлтгэсэн материалыг тарааж өгөх
- Цаас, олон өнгийн болон ердийн харандаа
- Хэвлэж болох дүрслэл тэмдэглэгээ (энхийн тагтаа, бөмбөрцөг, ном, хүүхэд, мод)



Сургалтын хөтөлбөр



Алхам 1: Танилцуулга – НҮБ гэж юу вэ? (5-7 мин)

Сурагчдаас асуух: НҮБ-ын талаар сонсож байсан уу? НҮБ ямар ажил хийдэг гэж та бодож байна вэ?

Тайлбарлах нь:

Нэгдсэн Үндэстний Байгууллага гэж юу вэ?

Нэгдсэн Үндэстний Байгууллага буюу НҮБ нь дэлхийн бараг бүх улс орон найз болж, хамтран ажилладаг нэг том баг юм.

НҮБ нь 1945 онд буюу Дэлхийн Хоёрдугаар дайны дараа даян дэлхийд энх тайвныг тогтоож дайн тулаанаас сэргийлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Нийт 193 гишүүн улс НҮБ-д байдаг. Энэ жил НҮБ-ын үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ой болж байна.

НҮБ олон тусгай байгууллагатай бөгөөд тус бүр нь чухал ажил хийдэг
Тухайлбал:

- WFP (Дэлхийн хүнсний хөтөлбөр) хоол хүнс дутмаг гэр бүлүүдэд тусламж үзүүлдэг
- WHO (ДЭМБ) хүмүүсийг эрүүл байхад тусалдаг
- UNESCO түүх, соёлыг хамгаалж, боловсролыг дэмждэг

Дэлхий хүмүүсийн сайн сайхны төлөө НҮБ-ын 30 гаруй байгууллага ажилладаг.

НҮБ ба Монгол Улс

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн болсон.

- Монголын хүүхэд, гэр бүлд боловсрол, эрүүл мэндийг сайжруулахад тусалдаг
- Байгаль орчныг хамгаалах, нүүдэлчдийн уламжлалыг дэмжиж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад тусалдаг
- Залуучуудад илүү олон боломж бий болгох, ирээдүйгээ өөрсдөө бүтээхэд нь дэмждэг
- Мөн Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (SDGs) хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг

НҮБ-ын Лого-г хүүхдүүдэд үзүүлнэ. Хүүхдүүдэд хандаж: Энэ жил НҮБ байгуулагдсаны 80 жилийн ойг буюу маш том Төрсөн өдрийн баярыг тэмдэглэнэ!

Видео: НҮБ гэж юу вэ? https://youtu.be/Rn_fD-OfcMg?si=b0K09EGmins5asNh



Сургалтын хөтөлбөр

Алхам 2: НҮБ хүмүүст яаж тусалдаг вэ? (10 мин)

Дараах 5 чиглэлийг танилцуулах (дүрсэн тэмдэглэгээ/зургууд ашиглах):

Энх тайван – дайныг зогсоож,
хүмүүсийг аюулгүй байлгах



Эрүүл мэнд – вакцин,
цэвэр усаар хангах



Хүүхдийн эрх – хүүхэд бүр
аюулгүй байж, хайр
халамжтайгаар өсч торних



Боловсрол – хүүхдүүдийг
сургуульд сурахад нь туслах



Эх дэлхий – байгаль дэлхийгээ
хамгаалах, уур амьсгалын
өөрчлөлттэй тэмцэх



Асуулт: Хүүхдүүд та нарт дээрх асуудлын аль нь хамгийн чухал вэ?



Сургалтын хөтөлбөр

Алхам 3: НҮБ-ын төрсөн өдрийн цагалбар (10 мин)

1948 – Хүний эрхийн
түгээмэл тунхаглал

2015 – Эх дэлхийг
хамгаалах Тогтвортой
хөгжлийн зорилгуудыг
баталсан

1945 – НҮБ
байгуулагдсан!

1989 – Хүүхдийн эрхийн
тухай конвенц

2025 – НҮБ
байгуулагдсаны 80
жилийн ой!



Хамтдаа сурцгаая: НҮБ байгуулагдсан цагаасаа хойш дэлхийд олон сайхан зүйлс хийсэн. Эдгээрээс 4-5 онцлох үйл явдлын тухай ярилцах
Дасгал ажиллах: Хүүхдүүдэд цагалбарыг илэрхийлэх картуудыг тарааж, тохирох дарааллаар зөв байршуулах дасгал ажиллуулах



Сургалтын хөтөлбөр

Алхам 4: Ирээдүйгээ бүтээх (15 мин)

- Сурагчид 2045 он буюу НҮБ-ын 100 жилийн ой болж байгааг төсөөлөх
- Сонголтууд/ санаанууд:
 1. Ямар дэлхийг хүсч байгаагаа дүрслэн үзүүлэх (энх тайван, сургууль, цэвэр дэлхий)
 2. Сонины нүүр хийх ("Дайн дажингүй дэлхий – НҮБ энх тайвныг тогтоолоо!")
 3. Төрсөн өдрийн мэндчилгээ: Хүүхдүүд жижигхэн карт эсвэл постер хийж, ирээдүйд ямар дэлхийд амьдрахыг хүсч буйгаа зурж, бичиж НҮБ-д илгээх

Алхам 5: Ойн баярыг тэмдэглэх (5 мин)

- "НҮБ-ын төрсөн өдөр"-ийг хамтдаа хөгжилтэйгээр тэмдэглэцгээе!
- Сонголтууд / санаанууд:
 1. Дуу эсвэл шүлэг: Хүүхдүүд хамтдаа богинохон энх тайван, дэлхийн тухай дуу эсвэл шүлэг уншиж дуулна
 2. Зураг солилцоо: Хүүхдүүд өөрсдийн зурсан "Ирээдүйн дэлхий"-ийн зургаа найзтайгаа солилцож, зургаа тайлбарлана
 3. "Сургууль, олон нийтийн дунд бүтээлээ солилцохыг дэмжих: Зохиосон шүлэг, дуу, зурсан зургаа #UN80, НҮБ-ын цахим хуудсуудыг дурдан цахим орчинд хуваалцах (зохимжтой гэж үзвэл)





СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /6-10 НАС/

Нэгдсэн Үндэстний Байгууллага үүсэн байгуулагдсаны 80 жилийн ой болж байна!

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) гэж юу вэ?

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь олон улс орнуудын баг юм. НҮБ нь дараах чиглэлээр ажилладаг. Үүнд:

- Энх тайвныг сахиулах
- Эрүүл мэндэд туслах
- Сургуулиудыг дэмжих
- Хүүхдүүдийг хамгаалах
- Эх дэлхийгээ хайрлан хамгаалах



Дасгал №1 – Тохирох зургийг зөв холбох

НҮБ-ын хийдэг ажлыг тохирох зургуудтай зураасаар зөв холбоорой.

Энх тайвныг сахиулах

Эрүүл мэндэд туслах

Сургуулиудыг дэмжих

Хүүхдүүдийг хамгаалах

Эх дэлхийгээ хайрлан хамгаалах





СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА /6-10 НАС/



Дасгал 2 – НҮБ-ын үйл ажиллагааны цагалбар

Онцлох нэг үйл явдлыг сонгож өөрийнхөө ойлгосныг
зургаар илэрхийлнэ үү

1945 – НҮБ анх байгуулагдсан!

1989 – Хүүхдийн эрхийн тунхаглалыг баталсан.

2015 – Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгуудыг баталсан.

2025 – НҮБ байгуулагдсаны 80 жилийн ой!



Дасгал 3 – НҮБ-ын 100 жилийн ой болох тэр үед НҮБ ямар зүйл хийсэн байгаасай гэж Та хүсч байна вэ ?

Цагирган дүрс дотор хүслээ зургаар илэрхийлээрэй:

НҮБүүсэнбайгуулагдсан100жилийн ойгоо тэмдэглэхүедбуюу 2045
он гэхэд Дэлхий ямар байгаасай гэж Чи хүсч байна вэ?

